

**Өвөрхангай аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2026 онд
улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын худалдан
авах ажиллагаанд дотоод аудит хийсэн тухай**

Өвөрхангай аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол улсын сангийн сайдын 2026 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 01/3386 дугаар Худалдан авах ажиллагааны тайлан, мэдээ ирүүлэх тухай албан бичгийн болон аймгийн Засаг даргын баталсан 29/03 тоот удирдамжийн дагуу Өвөрхангай аймгийн худалдан авах ажиллагааны явц байдлыг үнэлж дүгнэх, илэрсэн асуудалд зөвлөмж өгөх, дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилго:

Өвөрхангай аймагт 2026 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хэрэгжилт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж болон холбогдох журамд нийцэж байгаа эсэх, худалдан авах ажиллагааны ил тод, шударга, өрсөлдөх тэгш байдлыг хангаж байгаа эсэх, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцоо үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх зэрэгт үнэлэлт, дүгнэлт өгч, илэрсэн асуудлыг засаж сайжруулахад чиглэсэн зөвлөмж боловсруулахад оршино.

Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт: Дотоод аудитад худалдан авах ажиллагааны 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд зөвхөн улсын төсвийн хөрөнгөөр зохион байгуулсан тендер зохион байгуулалт, шалгаруулалт, үнэлгээний явц, гэрээ байгуулах шатны үйл ажиллагааг хамруулна.

Илэрсэн асуудлууд	Өгсөн зөвлөмжүүд
1. Худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөг цахим системд зөрүүтэй оруулсанаас тендерт оролцод өрсөлдөх тэгш боломж алдагдсан.	1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тендерийн мэдээллийг tender.gov.mn сайтад байршуулж, шинэчлэх үйл ажиллагаанд мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулах шат дараалсан хяналтын тогтолцоо нэвтрүүлж, хяналтын хуудас ашиглан баталгаажуулдаг болох;
2. Аймгийн Засаг даргаар батлуулсан төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанд худалдан авах ажиллагаа зохион байгуулдаггүй.	1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлахдаа захиалагч байгууллагууд тендер шалгаруулалт зарлахад шаардлагатай зураг төсөв, ажлын даалгавар, тоо хэмжээг төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанаас өмнө Худалдан авах ажиллагааны газарт ирүүлэх үүргийг захирамжид тусгаж мөрдүүлэх; 2. Захиалагч байгууллагуудаас ирүүлэх зураг төсөв, ажлын тоо хэмжээний мэдээллийн ирүүлэлтийн хугацаанд хяналт тавьж, хоцрогдол гаргасан тохиолдолд хариуцлага тооцох механизмыг

	хэрэгжүүлэх; 3. Захиалагч байгууллага болон Худалдан авах ажиллагааны газрын хооронд тендер шалгаруулалттай холбоотой мэдээллийг шуурхай солилцох дотоод зохицуулалт, хамтын ажиллагааны механизмыг бий болгох
3. Богд, Бүрд сумдын Цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн тендерийн үйл ажиллагаа эцэслээгүй байна.	1. Үнэлгээний хороо нь захиалагчаас ирүүлсэн зураг төсөв, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт, тавигдах нөхцөл шаардлага, зах зээлийн үнийн судалгааг бодит нөхцөлтэй уялдуулан нарийвчлан хянаж боловсруулан худалдан авах ажиллагааг зарлуулдаг байх; 2. Тендер шалгаруулалт амжилтгүй болсон тохиолдол бүрд шалтгаанд дүн шинжилгээ хийж, тендерийн баримт бичиг, шалгуур шаардлагыг сайжруулан давтан алдаа гарахаас сэргийлэх арга хэмжээ авч ажиллах; 3. Тендер шалгаруулалтын үнэлгээг хугацаа алдалгүй, шийдвэр гаргалтын үйл ажиллагааг хууль, журамд нийцүүлэн ил тод, үндэслэлтэй зохион байгуулж, гомдол маргаан үүсэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллах. 4. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулж, үнэлгээний хорооны гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх замаар давтан тендер зарлах, хугацаа алдах эрсдэлийг бууруулах.
4. Худалдан авах ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо хангалтгүй байна.	1. Худалдан авах үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон үнэлж, эрсдэлийн түвшинтэй уялдсан дотоод хяналтын жилийн төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг тогтмол тайлагнаж хэвшүүлэх; 2. Дотоод хяналтын үйл ажиллагааг зөвхөн хэлбэр төдий хэрэгжүүлэхээс сэргийлж, дотоод хяналтын нэгж, ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг дотоод журамд тодорхой тусган, хэрэгжилтийн үр дүнтэй уялдуулсан үнэлгээ, хариуцлагын тогтолцоог бий болгох; 3. Дотоод хяналтын ажилтнууд болон холбогдох албан хаагчдын хууль тогтоомж, дотоод хяналтын арга зүй, эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр мэргэшүүлэх, зөвлөн туслах арга хэмжээг тогтмол зохион байгуулах;

НЭГДСЭН ДҮГНЭЛТ:

Дотоод аудитаар аймгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа **“Сайжруулах шаардлагатай”** гэсэн дүгнэлтийг өгч байна.

Байгууллагын засаглалын төлөвшил “Томъёолсон” буюу 3 дугаар түвшинд, дотоод хяналтын тогтолцооны төлөвшлийн үнэлгээ “Давтамжтай” буюу 2 дугаар түвшинд, Эрсдэлийн удирдлагын төлөвшлийн үнэлгээ “Эхлэлийн” буюу 1 дүгээр түвшинд үнэлэгдлээ. Дээрх аудитын ажиглалтуудаас дүгнэхэд Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь худалдан авах ажиллагааг зохион байгуулах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байгаа боловч төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тендер шалгаруулалтын мэдээллийг цахим системд үнэн зөв, тухай бүр шинэчлэн байршуулах, байгууллага хоорондын мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг хангах, техникийн тодорхойлолт болон ажлын тоо хэмжээг бодит нөхцөлтэй уялдуулан боловсруулах үйл ажиллагаа хангалтгүй байгаагаас тендер шалгаруулалт төлөвлөгөөт хугацаандаа зохион байгуулагдахгүй хойшлох, олон удаа дахин зарлагдах, оролцогчгүй болох, гомдол маргаан үүсэх нөхцөл давтагдаж байна. Мөн байгууллагын хэмжээнд эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоо үр нөлөөтэй хэрэгжихгүй байгаа нь худалдан авах ажиллагааны явцад гарч буй алдаа, зөрчлийг урьдчилан илрүүлэх, таслан зогсоох, давтагдахаас сэргийлэх нөхцөлийг хангаж чадахгүй байна.

Эдгээр нөхцөл байдал нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хугацаа алдагдах, төсвийн хөрөнгийн үр ашиг буурах, худалдан авах ажиллагааны ил тод, шударга байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг үүсгэж байна.

Цаашид худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, байгууллага хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх, цахим системд байршуулж буй мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоог төлөвшүүлэх, албан хаагчдын хариуцлага, мэргэжлийн чадавхыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Аудитаар нийт 4 асуудал илэрсэн. Үүнээс тухайн 4 асуудал буюу нийт асуудлын 100 хувь “нөлөө ихтэй” гэж үзсэн.